

БАТЛАВ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН**

О.ЦОГТГЭРЭЛ

**ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Практик шаардлага

Цахимжилт, дижиталчлалын нөлөөгөөр иргэд ба шийдвэр гаргагчдын мэдээллийг олж авах хурд бараг адил болсон. Үүнтэй зэрэгцэн улс орны эдийн засгийн байдал муудаж, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчих үйлдлүүд ч сүүлийн үед олонтаа гарч, олон нийтийн анхаарлыг татаж байна. Иймээс иргэд олон нийт, олон нийтийн байгууллагуудын зүгээс эрх баригчдын алдаатай үйлдэл, бодлого, шийдвэрийг тухай бүрт эсэргүүцэн жагсаал, цуглааныг зохион байгуулж, зарим тохиолдолд зохион байгуулалтгүйгээр эсэргүүцлийн арга хэмжээнүүдийг хийсээр байна.

Гэвч өнөөгийн хэрэгжиж буй хууль эрх зүйн зөрчлийн улмаас жагсаал хийх зөвшөөрлөө хүлээж багадаа 3 хонох, жагсаалын зорилго, агуулгад тухайн шатны засаг дарга субъектив байдлаар хандаж жагсаалыг үл зөвшөөрөх гэх мэт үйлдлүүд олонтаа давтагдав. Мөн зохион байгуулалтгүйгээр тухайн цаг үеийн асуудлаас үүдэн иргэд өөрсдөө нэгдсэн “Аяндаа цугласан жагсаал”-ыг өнөө хүртэл хуулиар томьёолж өгөөгүйгээс уг цуглааны сэдлийг төрүүлсэн zaluuсыг ч зөрчлийн хуулиар шийтгэх явдал ч хэд хэдэнтээ тохиолдов. Улмаар ковидын нөхцөл байдалтай холбоотойгоор иргэдийн жагсах, цуглах эрхийг ч зөвшөөрлөөр болон хүчээр хорих оролдлогууд сүүлийн 2 жилийн туршид үргэлжлэв.

Энэ бүхэнд иргэдэд заяагдсан үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг зөрчиж байна гэж үзэн, үүн дээрх зөрчилтэй зүйл, заалтыг засан сайжруулахаар уг хуулийн төслийг боловсруулж байна.

1.2.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд тус зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж нарийвчлан зааж өгсөн. Улмаар 1992 оны Үндсэн хуультай нийцүүлэн 1994 онд “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-ийг УИХ-аас баталсан. Улмаар 2005 онд уг хуулинд өөрчлөлт оруулж, жагсаал, цуглаан хийхийн тулд зөвшөөрөл авдаг байсныг мэдэгдэл болгон өөрчилсөн боловч өнөөг хүртэл хуулийн хэрэглээнд мэдэгдэл биш зөвшөөрөл утгаар ойлгогдоор ирсэн. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлд ч “Хүн бүр чөлөөтэй тайван хуран цуглаж, эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан. Иймээс иргэддээ Үндсэн хуулиар баталгаажуулсан өгсөн эрхийг нь уг хуулиар улам ойртуулан өгөх шаардлага байна.

Алсын хараа 2050 бодлогын баримт бичгийн зорилт 5.5-д “Иргэний нийгэм-хувийн хэвшилт-төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоог бүрдүүлнэ” гээд I үе шат буюу 2021-2030 онд “Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоо бэхжиж, үр нөлөө дээшилнэ” гэж, Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагаан хөтөлбөрийн 4.4.11-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна” гэж заасан байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр боловсруулагдах бөгөөд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн баталгааг хангаж өгөх үүднээс дараах заалтуудыг тусгана:

- 1/ Жагсаал, цуглаан зохион байгуулахдаа тухайн нэгжийн засаг даргад мэдэгдэж зөвшөөрөл авдаг байсныг зөвхөн мэдэгддэг болгож, зөвшөөрлийн биш мэдэгдлийн тогтолцоо руу бүрэн шилжүүлнэ.
- 2/ Аяндаа үүссэн цуглааныг албажуулан хуульчилж, зохион байгуулалтгүй ийм төрлийн жагсаалд мэдэгдэл авдаггүй байхаар хуульчлан зааж өгнө.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна. Үүнд:

- 1/ Жагсаал, цуглаан зохион байгуулахдаа зөвшөөрөл авах биш мэдэгддэг болгож, мэдэгдснээр тухайн арга хэмжээг эхлүүлэх боломжийг бүрдүүлж өгснөөр иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Үндсэн хуулиар зааж өгсөн эрхийг баталгаажуулж өгнө.
- 2/ Технологийн ололт, цахим хэрэглээний өсөлттэй холбоотойгоор тодорхой шийдвэрийг хэлэлцэх үед эсэргүүцэл, түүнийг даган бий болдог аяндаа үүссэн цуглааныг хуульчлан зааснаар Үндсэн хуульд зааж өгсөн дээрх эрхийн баталгааг хангаж өгнө.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэсэн заалтыг илүү иргэндээ ойртуулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--ооо--